

## АЖЛЫН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ГЭРЭЭ

2023 оны 11 сарын 24

Дугаар. 1013/08

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчтэй хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Иргэн Д.Одноо /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг үндэслэл болгож дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

### Нэг. Гэрээний зорилго

1.1. Гэрээний зорилго нь Гүйцэтгэгч талаас “Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухны засварын ажлын төсөв боловсруулах” ажлыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан ажлын жагсаалтыг гэрээнд заасан хугацаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, чанарын стандартын шаардлагын дагуу гүйцэтгэх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохиролцсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 2.1 Энэ гэрээт ажлын нийт үнэ 7,451,940 /долоон сая дөрвөн зуун тавин нэгэн мянга есөн зуун дөч/-н төгрөг бөгөөд үнийн дунд холбогдох татвар, хураамж, бусад зардлууд бүгд орсон байна.
- 2.2 Захиалагчаас гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 2.3 Гэрээт ажлын төлбөрийг ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа, захиалагч ажлын тайлан дүгнэлт болон бусад баримт бичгийг хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу 14 хоногт багтаан гүйцэтгэгчийн Хаан банкны 5022380218 тоот дансанд шилжүүлнэ.

### Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Гүйцэтгэгч гэрээт ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний дотор 8 /найм/ хоногт багтаан гүйцэтгэж дуусгана.

### Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Захиалагч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
  - 4.1.1 Гүйцэтгэгчийн энэхүү Гэрээний дагуу гүйцэтгэж буй ажил, үйлчилгээг гэрээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэхийг шаардах
  - 4.1.2 Захиалагч ажлын гүйцэтгэл, явц, үр дүнгийн талаар тогтмол, тайлан мэдээг тухай бүр гүйцэтгэгчээс авах”
  - 4.1.3 Гүйцэтгэгч гэрээгээр тогтоосон хугацаанд ажлаа гүйцэтгээгүй бол хугацаа хоцорсонтой холбоотой аливаа нэмэлт зардал, бодит хохирлыг төлөхийг эсвэл гэрээнээс татгадзаж учирсан хохирлыг шаардах”

Захиалагч:

1/5

Гүйцэтгэгч:

- 4.1.4 Засварын ажлын төсөв боловсруулах явцад Захиалагчийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулах бол талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 4.1.5 Захиалагч нь ажил эхлэх үед ажил гүйцэтгэгчийг үргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт, засварын ажлын батлагдсан даалгавар болон бусад мэдээллийг бэлтгэн ажил гүйцэтгэгчид өгнө.
- 4.1.6 Захиалагч нь төсөв дууссаны дараа өгсөн даалгаврын дагуу хийсэн эсэхийг шалгаж, ажлын гүйцэтгэл хүлээн авах актаар хүлээн авна.
- 4.1.7 Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч төлбөрийг гэрээнд заасан хугацаандаа төлнө.
- 4.1.8 Гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд шаардлагатай үнэн зөв бичиг баримт, мэдээллийг гаргаж өгөх, дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.9 Энэхүү гэрээний дагуу ажил гүйцэтгэхтэй холбоотой аливаа мэдэгдэл, мэдээллийг гүйцэтгэгчид яаралтай мэдэгдэнэ.
- 4.1.10 Тухайн төсвийн магадлалыг захиалагч тал хариуцна.
- 4.2 Гүйцэтгэгч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- 4.2.1 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг гаргаж өгөхийг захиалагчаас шаардах”
- 4.2.2 Гэрээт ажлын хөлсийг Гэрээнд заасан хугацаанд төлөхийг Захиалагчаас шаардах”
- 4.2.3 Төсвийн ажлын даалгавартай уялдуулан одоо мөрдөгдөж буй үнэ бүрдлийн норм дүрэм, зах зээл дээр боловсруулагдаж буй материалын үнийг тусган гүйцэтгэнэ.
- 4.2.4 Төсвийн ажлыг батлагдсан ажлын даалгавар, төрийн захиргааны төв байгууллагаар батлагдсан төсвийн программ хангамж ашиглан гүйцэтгэж хүлээлгэн өгнө.
- 4.2.5 Гүйцэтгэгч нь төсвийн ажил гүйцэтгэх явцад захиалагчид ажлын явцын талаар мэдээлэл өгөх ба захиалагчаас өгсөн ажлын гүйцэтгэлтэй холбоотой санал, заавар, дүгнэлтийг хүлээн авч, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн хүрээнд биелүүлнэ.
- 4.2.6 Гүйцэтгэгч нь төсөв хийх явцад Захиалагчид ажлын явцын талаар мэдээлэл өгөх ба Захиалагчаас өгсөн ажлын гүйцэтгэлтэй холбоотой санал, заавар, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
- 4.2.7 Төсвийн магадлалаар шалгах, хянах, батлуулах, хэрэгжүүлэх явцад алдаа, зөрчил илэрвэл түүнийг Гүйцэтгэгч тал үнэ төлбөргүй шуурхай шийдвэрлэж өгнө.
- 4.2.8 Боловсруулж дуусган төсвийн ажлын үр дүнг гэрээ дүгнэсэн актаар Захиалагчийн эрх бүхий төлөөлөгчид шилжүүлнэ.
- 4.2.9 Гэрээг цуцлах буюу гэрээг дуусгавар болгох тохиолдолд талууд гэрээг дүгнэн төлбөр тооцоо нийлж акт үйлдэх бөгөөд ажил гүйцэтгэгч нь өөрт байгаа ажил гүйцэтгэсэнтэй холбоотой PDFматериалыг Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 4.2.10 Ажил гүйцэтгэх хугацаанд үйлдвэр дээр ирж ажиллах үедээ Эрчим хүчний системд мөрдөгдөж буй ТАД, ААД болон холбогдох бусад дүрэм журмыг мөрдөж ажиллана.

### **Тав.Гэрээ дүгнэсэн акт**

- 5.1 Ажил гүйцэтгэгч нь зураг төслийг боловсруулах ажлыг гүйцэтгэж ажлын тайлан, төсвийг Захиалагч талаас ирүүлсэн эзлэхүүний хамт З хувийг Захиалагч талд хүлээлгэн өгч гэрээг дүгнүүлнэ.
- 5.2 Гэрээ дүгнэсэн актад талууд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 5.3 Гэрээ дүгнэсэн акт нь гэрээний салшгүй хэсэг байна.

### **Зургаа. Гэрээ цуцлах үндэслэл**

- 6.1 Талууд аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар гэрээг цуцалж болно.

Захиалагч:

2/5

Гүйцэтгэгч:

## **6.2 Захиалагч дараах тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:**

- 6.2.1 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг чанар стандартын шаардлага хангаагүй, ажлын доголдол гаргасан, ут зөрчлийг арилгах арга хэмжээ аваад үр дүнд хүрээгүй бол;
- 6.2.2 Гүйцэтгэгч ажлыг албан ёсоор бүх нийтийн амралтын өдрөөс бусад хуанлийн 5-с дээш хоног орхиж явсан, захиалагчийн шаардлага зааварчилгааг биелүүлээгүй;
- 6.2.3 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бол Захиалагч гэрээг цуцлах эрхтэй.
- 6.2.4 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа захиалагч болон бусад этгээдэд ноцтой хохирол учруулсан, тэдгээрийн нэр хүндэд халдсан бол;

## **6.3 Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.**

- 6.3.1 Захиалагч гэрээнд заасан ажлын үр дүнг хүлээн авсан боловч ажлын хөлс төлөх үүргээ биелүүлээгүй;
- 6.3.2 Захиалагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа гүйцэтгэгч болон бусад этгээдэд ноцтой хохирол учруулсан, тэдгээрийн нэр хүндэд халдсан бол;

## **Долоо. Хариуцлага**

- 7.1 Талуудын аль нэг гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, гэрээний хугацаанд гүйцэтгээгүй ажлын нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% - иас хэтрэхгүй байна.
- 7.2 Алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 7.3 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Хангамжийн мэргэжилтэн Ш.Гантулга хариуцан ажиллана. Утас-94117556.
- 7.4 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Иргэн Д.Одноо хариуцан ажиллана. Утас- 99078683.
- 7.5 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
  - Ажлын төсөв
  - Гүйцэтгэсэн ажлын тайлан

## **Найм. Давагдашгүй хүчин зүйл**

- 8.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, нийтийг хамарсан болон цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт, эрх бүхий байгууллагын хорио цээр тогтоосон шийдвэр болон бусад нөхцөлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцөлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 8.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцнө.

## **Ес. Гэрээг цуцлах үндэслэл**

- 9.1 Гүйцэтгэгч нь хийгдэх ажлыг энэхүү гэрээний 2.1-т заасан хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид албан ёсоор бичгээр өгнө. Гүйцэтгэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.
- 9.2 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

## Арав. Бусад нөхцөл

- 10.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 1 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 10.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 10.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 10.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 10.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 10.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 10.7 Талууд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон олж авсан аливаа баримт, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд нөгөө тал зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй, гэрээнд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй. Энэхүү нууцыг хадгалах үүрэг нь гэрээ дуусгавар болсон ч хүчинтэй хэвээр байна.
- 10.8 Энэхүү гэрээтэй холбогdon гарах маргаан болон хоёр талын харилцан үл ойлголцол байдлыг талууд харилцан зөвшилцэж ойлголцох, бие биеэ хүндэтгэх замаар шийдэхийг эрмэлзэх ба тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол улсын харьялах шүүхээр шийдвэрлүүлнэ.

Захиалагч:



4/5


Гүйцэтгэгч:



БАТЛАВ

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 М.МОНХӨӨ

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Э.МОНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 О.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Т.БАТТУЛГА

ХУУЛИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

 Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Ш.ГАНТУЛГА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, СХД, 19-р хороо,  
87/Б байрх 48 тоот  
Утасны дугаар: 99078683

Захиалагч:



5/5

Гүйцэтгэгч:



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨВЧИН

